

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/19/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Д.Баярсайхан  
Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn  
Аудитын менежер Б.Долгорсүрэн  
Утас: 261740 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn  
Ахлах аудитор П.Амарсанаа  
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn  
Аудитор Ж.Мөнхтуул  
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан .....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	10
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрхзүйн орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	14
3.5.3 Нэмэлт төсөв .....	14
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
3.5.5 Хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүн .....	15
4. Аудитын тайлан .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	19
5. Аудитын илрүүлэлт .....	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн албаны зөвлөл 30 жилийн хугацаанд анх удаа 21 аймгийн 330 сум, 9 тосгонд очиж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, төрийн албан хаагчийг сургалт, мэдээллээр хангах, мэргэшил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, санал хүсэлтийг сонсох, ажиллах нөхцөл байдалтай танилцах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу хууль бус шийдвэр гаргасны улмаас төрийн албан хаагч хохирсныг шүүх тогтоосны дагуу 71 иргэний 478.2 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн албаны зөвлөл нь тайлант онд төсвийн урсгал зардлаас байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах, төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийн цахим систем, ерөнхий болон тусгай шалгалтын цахим системийг хөгжүүлэх, төрийн албан хаагчийн ур чадвар, сургалт хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, төрийн албатай холбоотой судалгаа, шинжилгээ хийлгэх зэрэг ажилд нийт 6,084.1 сая төгрөгийг зарцуулахаар худалдан авах ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, үүнээс 4,494.4 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө бэлтгэж, данс бүртгэлд тусгасан байна.

### **Бусад асуудал**

Төрийн байгууллага, төрийн албан хаагч, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагыг тогтоож, Стандарт,

хэмжил зүйн газрын даргын 2025 оны С/12 дугаар тушаалаар “MNS 7068:2025” стандартыг батлуулсан байна.

Төрийн албаны зөвлөл нь 2025 онд байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэн Канад, Казахстан улстай “Санамж бичиг”, Канад улстай “Эрмэлзлийн бичиг”-ийг байгуулж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	169,384.7	633,405.5
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	97,207.9	228,093.1
3	АВЛАГА	-	248,497.0
4	УРЬДЧИЛГАА	9,400.0	39,805.1
5	БАРАА МАТЕРИАЛ	62,776.8	117,010.3
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,507,627.3	6,482,410.2
7	Биет хөрөнгө	949,979.0	2,456,174.4
8	Биет бус хөрөнгө	1,557,648.3	4,026,235.8
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,677,012.0	7,115,815.7
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,325.0	228,093.1
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,325.0	228,093.1
12	Өглөг	19,325.0	228,093.1
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,657,687.0	6,887,722.6
14	Засгийн газрын хувь оролцоо	2,657,687.0	6,887,722.6
15	Засгийн газрын оруулсан капитал	434,739.6	434,739.6
16	Хуримтлагдсан үр дүн	2,222,077.9	6,452,113.5
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869.5	869.5
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,677,012.0	7,115,815.7

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,725,172.1	14,893,901.8
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	856,296.8	14,893,901.8
3	Тусламжийн орлого	-	14,116,841.1
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,268,166.8	10,599,105.6
5	УРСГАЛ ЗАРДАЛ	8,268,166.8	10,599,105.6
6	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,676,547.1	10,008,113.7
7	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,895,690.1	5,509,131.1
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	473,172.8	677,573.9
9	Хангамж, бараа материалын зардал	190,854.0	209,561.5
10	Эд хогшил, урсгал засварын зардал	9,890.0	29,519.6
11	Томилолт, зочны зардал	69,430.5	289,418.4
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,273,610.4	2,358,490.4
13	Бараа үйлчилгээний бусад зардал	763,899.5	934,418.8
14	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,591,619.7	590,992.0
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	457,005.2	4,294,796.1
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	75,022.1	64,760.6
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(75,022.1)	(64,760.6)
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	381,983.2	4,230,035.6

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,275,703.8	-	2,275,703.8
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,275,703.8	-	2,275,703.8
3	Тайлант үеийн үр дүн	381,983.2	-	381,983.2
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,657,687.0	-	2,657,687.0
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,657,687.0	-	2,657,687.0
6	Тайлант үеийн үр дүн	4,230,035.5	-	4,230,035.5
7	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,887,722.6	-	6,887,722.6

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,585,833.4	14,803,819.7
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	716,958.2	14,803,819.7
3	Нийтлэг татварын бус орлого	716,958.2	686,978.6
4	Тусламжийн орлого	-	14,116,841.1
5	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,998,676.7	10,178,503.8
6	УРСГАЛ ЗАРДАЛ	7,998,676.7	10,178,503.8
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,407,056.9	9,339,599.2
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,898,812.9	5,509,131.1
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	483,453.8	678,158.3
10	Хангамж, бараа материалын зардал	146,650.1	201,504.0
11	Эд хогшил, урсгал засварын зардал	12,921.9	29,408.8
12	Томилолт, зочны зардал	69,430.5	318,473.4
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,287,666.8	2,430,445.7
14	Бараа үйлчилгээний бусад зардал	508,121.1	172,477.8
15	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,591,619.7	838,904.6
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	587,156.8	4,625,315.9
17	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	770,790.8	4,494,430.7
18	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	770,790.8	4,494,430.7
19	Дотоод эх үүсвэрээр	770,790.8	4,494,430.7
20	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(770,790.8)	(4,494,430.7)
21	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(183,634.1)	130,885.2
22	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	280,842.0	97,207.9
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	97,207.9	228,093.1

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	15,125,100,600.00	13,846,928,891.50	1,278,171,708.50	91.5
Татварын бус орлого	15,125,100,600.00	13,846,928,891.50	1,278,171,708.50	91.5
Нийтлэг татварын бус орлого	200,000,000.00	476,558,817.24	(276,558,817.24)	238.3
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	200,000,000.00	476,558,194.24	(276,558,194.24)	238.3
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	623.00	(623.00)	
Тусламжийн орлого	14,925,100,600.00	13,370,370,074.26	1,554,730,525.74	89.6
Төсвөөс санхүүжих	14,925,100,600.00	13,370,370,074.26	1,554,730,525.74	89.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,125,100,600.00	13,641,928,268.50	1,483,172,331.50	90.2
УРСГАЛ ЗАРДАЛ	15,125,100,600.00	13,641,928,268.50	1,483,172,331.50	90.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,963,392,500.00	13,497,768,827.20	1,465,623,672.80	90.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,121,537,200.00	5,509,131,139.58	612,406,060.42	90.0
Үндсэн цалин	3,435,353,300.00	3,194,131,635.11	241,221,664.89	93.0
Нэмэгдэл	1,362,261,200.00	1,321,045,121.24	41,216,078.76	97.0
Унаа хоолны хөнгөлөлт	452,682,100.00	364,031,284.24	88,650,815.76	80.4
Урамшуулал	871,240,600.00	629,923,098.99	241,317,501.01	72.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	738,967,000.00	678,158,316.24	60,808,683.76	91.8
Тэтгэврийн даатгал	517,782,900.00	468,326,846.31	49,456,053.69	90.4
Тэтгэмжийн даатгал	53,278,100.00	52,691,066.27	587,033.73	98.9
ҮОМШӨ-ний даатгал	26,710,400.00	26,902,301.32	(191,901.32)	100.7
Ажилгүйдлийн даатгал	29,421,100.00	26,572,937.01	2,848,162.99	90.3
Эрүүл мэндийн даатгал	111,774,500.00	103,665,165.33	8,109,334.67	92.7
Хангамж, бараа материалын зардал	269,066,800.00	201,000,999.38	68,065,800.62	74.7
Бичиг хэрэг	49,268,100.00	35,354,870.00	13,913,230.00	71.8
Тээвэр, шатахуун	81,760,700.00	71,656,289.00	10,104,411.00	87.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,344,600.00	53,356,524.38	21,988,075.62	70.8
Ном, хэвлэл	15,000,000.00	10,750,000.00	4,250,000.00	71.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,693,400.00	29,883,316.00	17,810,084.00	62.7
Эд хогшил, урсгал засварын зардал	970,016,300.00	960,470,221.00	9,546,079.00	99.0
Багаж, техник, хэрэгсэл	881,758,000.00	881,729,390.00	28,610.00	100.0
Тавилга	55,600,000.00	49,590,000.00	6,010,000.00	89.2
Урсгал засвар	32,658,300.00	29,150,831.00	3,507,469.00	89.3
Томиллолт, зочны зардал	325,861,000.00	318,473,438.00	7,387,562.00	97.7
Гадаад албан томиллолт	71,751,500.00	70,659,389.00	1,092,111.00	98.5
Дотоод албан томиллолт	254,109,500.00	247,814,049.00	6,295,451.00	97.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,348,044,200.00	5,658,056,943.00	689,987,257.00	89.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,204,043,100.00	1,541,368,090.00	662,675,010.00	69.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,990,900.00	-	1,990,900.00	-
Даатгалын үйлчилгээ	248,900.00	-	248,900.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	672,300.00	672,300.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-	22,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,118,669,800.00	4,116,016,553.00	2,653,247.00	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,397,200.00	-	22,397,200.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	189,900,000.00	172,477,770.00	17,422,230.00	90.8

Бараа үйлчилгээний бусад зардал	47,931,700.00	36,264,020.00	11,667,680.00	75.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	141,968,300.00	136,213,750.00	5,754,550.00	95.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,708,100.00	144,159,441.30	17,548,658.70	89.1
Бусад урсгал шилжүүлэг	161,708,100.00	144,159,441.30	17,548,658.70	89.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000.00	-	1,000.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,182,500.00	135,159,441.30	2,023,058.70	98.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,524,600.00	9,000,000.00	15,524,600.00	36.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	205,000,623.00	(205,000,623.00)	
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(205,000,623.00)	205,000,623.00	
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(205,000,623.00)	205,000,623.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
Төсвийн байгууллага	2	2	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	78	73	5	93.6
Удирдах ажилтан	28	27	1	96.4
Гүйцэтгэх ажилтан	49	45	4	91.8
Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	73	5	93.6
Ажлын албаны албан хаагч (АА)	57	54	3	94.7
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14	12	2	85.7
Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	-	100.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2	2	-	100.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	4	2	2	50.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	4	2	2	50.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	336,242,004.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	336,242,004.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	336,242,004.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	336,242,004.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,990,800.00
УРСГАЛ ЗАРДАЛ	326,990,800.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,990,800.00
Хангамж, бараа материалын зардал	503,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	29,999,800.00
Багаж, техник, хэрэгсэл	29,999,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,488,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,488,000.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	9,251,204.00
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(9,251,204.00)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(9,251,204.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Төрийн албаны зөвлөл “Иргэдэд ойр, уян хатан, идэвхтэй, санаачилгатай бөгөөд цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн манлайлагч менежер бүхий төрийн албыг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилготой бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах;
- Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх;
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлэх, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмыг батлах;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, төрийн албаны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө үзүүлэх, чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх; хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх, биелэлтийг хангах, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Төрийн албаны зөвлөл Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил гүйлгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай болон бусад хууль тогтоомжийг мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төрийн албаны зөвлөлийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй бөгөөд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,438.8 сая төгрөгөөр буюу 166.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	97.2	228.1	130.9
Авлага	0.0	248.5	248.5
Урьдчилгаа	9.4	39.8	30.4
Бараа материал	62.8	117.0	54.2
Үндсэн хөрөнгө	2,507.6	6,482.4	3,974.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,677.0</b>	<b>7,115.8</b>	<b>4,438.8</b>
Өр төлбөр	19.3	228.1	208.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,657.7	6,887.7	4,230.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,677.0</b>	<b>7,115.8</b>	<b>4,438.8</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 228.1 сая төгрөг болж, өмнөх оноос 130.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>97.2</b>	<b>228.1</b>	<b>130.9</b>
<b>Төгрөг</b>	<b>97.2</b>	<b>228.1</b>	<b>130.9</b>
Төрийн сангийн харилцах	19.3	228.1	208.8
Ахмадын сангийн харилцах	77.9	0.0	(77.9)
<b>Дүн</b>	<b>97.2</b>	<b>228.1</b>	<b>130.9</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны 228.1 сая төгрөгийн үлдэгдэлд Төрийн албаны зөвлөлийн гэрээт ажлын 224.1 сая төгрөгийн, Ёс зүйн хорооны гэрээт ажлын 3.9 сая төгрөгийн барьцаа тус тус байршиж байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 248.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	0.0	247.9	247.9
Байгууллагаас авах авлага	0.0	0.6	0.6
<b>Дүн</b>	<b>0.0</b>	<b>248.5</b>	<b>248.5</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд татаас санхүүжилтийн 247.9 сая төгрөгийн, байгууллагаас авах 0.6 сая

төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна. Татаас санхүүжилтийн авлагад Төрийн албаны зөвлөлийн тайлант оны 205.0 сая төгрөгийн давсан орлогын, ахмадын сангийн 42.9 сая төгрөгийн үлдэгдэл, байгууллагаас авах авлагын 0.6 сая төгрөгийн үлдэгдэлд Ёс зүйн хорооны нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлсөн 0.6 сая төгрөгийн авлагууд тус тус бүртгэлтэй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 39.8 сая төгрөг болж, өмнөх оноос 30.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	9.4	10.8	1.4
Урьдчилгаа тооцоо	0.0	29.0	29.0
<b>Дүн</b>	<b>9.4</b>	<b>39.8</b>	<b>30.4</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлангийн ном хэвлүүлэх 10.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр, урьдчилгаа тооцоо дансны 29.0 сая төгрөгийн үлдэгдэлд Төрийн албаны зөвлөлийн 18.6 сая төгрөгийн, Ёс зүйн хорооны 10.4 сая төгрөгийн томилолтын зардлын урьдчилгаа тус тус бүртгэлтэй байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 117.0 сая төгрөг болж, өмнөх оноос 54.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Хангамжийн материал</b>	<b>62.8</b>	<b>117.0</b>	<b>54.2</b>
Бичиг хэргийн материал	20.7	26.7	6.0
Аж ахуйн материал	1.6	2.5	0.9
Түлш, шатах тослох материал	0.0	8.6	8.6
Бусад хангамжийн материал	40.5	79.2	38.7
<b>Дүн</b>	<b>62.8</b>	<b>117.0</b>	<b>54.2</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл тайлант онд худалдан авсан 248.7 сая төгрөгийн, Эдийн засаг хөгжлийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 15.8 сая төгрөгийн бараа материалаар тус тус нэмэгдэж, үйл ажиллагаанд 210.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан 54.2 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 6,482.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3,974.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>950.0</b>	<b>2,456.2</b>	<b>1,506.2</b>
Авто тээврийн хэрэгсэл	0.0	38.4	38.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	722.3	2,121.3	1,399.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	224.9	295.3	70.4
Бусад үндсэн хөрөнгө	2.8	1.2	(1.6)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,557.6</b>	<b>4,026.2</b>	<b>2,468.6</b>
Программ хангамж	271.3	2,723.7	2,452.4

Бусад биет бус хөрөнгө	1,286.3	1,302.5	16.2
<b>Дүн</b>	<b>2,507.6</b>	<b>6,482.4</b>	<b>3,974.8</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл тайлант онд урсгал төсвөөс худалдан авсан 4,494.4 сая төгрөгийн, Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 38.2 сая төгрөгийн, ТӨБЗГ-ын 2025 оны 424 дүгээр тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлсэн 248.3 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 449 дүгээр тогтоолоор акталсан 128.7 сая төгрөгийн, Төрийн албаны салбар зөвлөл рүү үнэ төлбөргүй шилжүүлсэн 68.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, тайлант оны элэгдлийн зардал 609.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалан 3,974.8 сая төгрөгөөр өссөн нь байна.

### 3.4.6 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 228.1 сая төгрөг болж, өмнөх оноос 208.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>19.3</b>	<b>228.1</b>	<b>208.8</b>
Байгууллагад төлөх өглөг	19.3	228.1	208.8
<b>Дүн</b>	<b>19.3</b>	<b>228.1</b>	<b>208.8</b>

/ сая төгрөгөөр/

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагад төлөх өглөг дансны 228.1 сая төгрөгийн үлдэгдэлд тайлант оны гэрээт ажлын барьцааны өглөг бүртгэлтэй байна.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,887.7 сая төгрөг болж, өмнөх оноос 4,230.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,657.7</b>	<b>6,887.7</b>	<b>4,230.0</b>
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	434.7	434.7	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,222.1</b>	<b>6,452.1</b>	<b>4,230.0</b>
Өмнөх үеийн үр дүн	1,840.1	2,222.1	382.0
Тайлант үеийн үр дүн	382.0	4,230.0	3,848.0
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>869.5</b>	<b>869.5</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>2,657.7</b>	<b>6,887.7</b>	<b>4,230.0</b>

/ сая төгрөгөөр/

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант онд урсгал төсвөөс бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бүртгэснээс шалтгаалсан 4,230.0 сая төгрөгөөр өссөн байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 24,631.9 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,332.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний

бусад зардлыг 3,574.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 976.2 сая төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 775.3 сая төгрөгөөр, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 746.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 218.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 135.2 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 117.9 сая төгрөгөөр нийт 5,211.6 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 19,420.3 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд баталсан төсвийг 4,295.2 сая төгрөгөөр бууруулан тодотгосон бөгөөд Төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 4 арга хэмжээг улсын төсвийн 15,125.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13,370.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 476.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нийт зардлын гүйцэтгэл 13,641.9 сая төгрөг буюу 90.0 хувь байна.

*Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт /хувь/
70401	<b>Төрийн албаны ерөнхий удирдлага</b>	<b>15,125.1</b>	<b>13,641.9</b>	<b>1,483.2</b>	<b>90.0</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,759.3	11,956.4	802.9	94.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	293.4	281.9	11.5	96.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	161.7	144.2	17.5	89.0
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,910.7	1,259.5	651.2	66.0

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тус зөвлөл нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Төрийн албаны зөвлөлийн нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 336.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, бараа үйлчилгээний зардалд 327.0 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 9.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Төрийн албаны зөвлөл тайлант онд 78 орон тоотой ажиллахаар батлуулснаас орон тооны 9 хувийн цомхотголын хүрээнд баталсан орон тоог бууруулан 73 орон тоотой ажилласан байна. Цалингийн зардалд 6,121.5 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 5,509.1 сая төгрөгийг зарцуулсан;
2. Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/37 дугаар тушаалаар Төрийн албаны зөвлөлийн албан хаагчдын хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 5.0 мянган төгрөг, 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тушаалаар Ёс зүйн хорооны албан хаагчдын хоолны хөнгөлөлтийг 20.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 5.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд 452.7 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 364.0 сая төгрөгийг зарцуулсан;
3. Гадаад томилолтын зардалд 71.8 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 70.7 сая төгрөгийг зарцуулсан;
4. Тайлант онд байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд гараагүй;

5. Төрийн албаны зөвлөл 4,380.6 сая төгрөгийн өртөгтэй 9 нэр төрлийн хүний нөөцийн, шалгалтын, санхүүгийн программ хангамж, Ёс зүйн хороо 80.5 сая төгрөгийн 2 нэр төрлийн бүртгэлийн болон санхүүгийн программ бүртгэлтэй байгааг бүрэн ашиглаж байна. Тайлант онд программ хөгжүүлэхэд урсгал төсвөөс 2,664.9 сая төгрөг, засвар үйлчилгээний зардалд 246.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
6. Хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, зардал гараагүй;
7. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан бөгөөд нийт 3,583.5 сая төгрөгийн 6 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 5, харьцуулалтын аргаар 1 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд 2,460.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар нэмэлтээр 3 удаа төлөвлөгөөг баталсан байна.

Баталсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан хувь хүн, хуулийн этгээдтэй нийт 5,775.8 сая төгрөгийн гэрээг байгуулж, гэрээний гүйцэтгэл 100.0 хувь байна.

### 3.5.5 Хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүн

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд дараах арга хэмжээ, зорилтот түвшнийг баталжээ.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт*

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн		Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд		Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Үр дүн
<b>Төрийн албаны ерөнхий удирдлага</b>							
13.1.1	Төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлж, сайжруулна.	13.1.1.1	Хууль тогтоомжийн төсөл	2023	Т	1	1
		13.1.1.2	Дүрэм, журмын төсөл	2023	Т	10	8
		13.1.1.3	Стандартын төсөл	2023	Т	1	1
		13.1.1.4	Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт	2023	800	1500	2411
		13.1.1.5	Чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад өгсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө	2023	10	30	30
13.1.2	Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, Монгол хэлний ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчилнэ.	13.1.2.1	Сорил, даалгавар, асуулт, хариултын сангийн баяжилтыг чанаржуулах	2023	1000	3000	12500
		13.1.2.2	Чадварт суурилсан журмыг баталж, мөрдөх шийдвэр	2023	Т	1	1
		13.1.2.3	Сонгон шалгаруулалт	2023	1000	1500	4960
		13.1.2.4	Цахим системийн хөгжүүлэлт	2023	40	100	100
13.1.3	Хүний нөөцийн аудитын тогтолцоог	13.1.3.1	Тогтоол, шийдвэр	2023	Т	8	8

	бүрэн бүрдүүлж, чадахуйн зарчмын хэрэгжилтэд хүний нөөцийн аудит, бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	13.1.3.2	Хүний нөөцийн аудит	2023	2	8	16
		13.1.3.3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, тайлан	2023	Т	3	3
13.1.4	Төрийн албаны хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулна.	13.1.4.1	Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц	2023	260/3500	280	280
		13.1.4.2	Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	2023	100,000	200,000	478,200
13.1.5	Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан ажил үүргийн давхцалыг арилгах, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулж, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.	13.1.5.1	Бодлогын санал	2023	Т	1	1
		13.1.5.2	Судалгааны ажил	2023	Т	1	1
13.1.6	Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, цахим системийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.	13.1.6.1	Системийн модуль хөгжүүлэлт, нэвтрүүлэлт	2023	40	90	90
		13.1.6.2	Цахим мэдээлэлд нээлттэй хандах албан хаагч	2023	Т	227	100.35
		13.1.6.3	Мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдал	2023	60	100	80.0
		13.1.6.4	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ	2023	Т	1	1.0
		13.1.6.5	Цахим системийн хатуу дэд бүтцийн шинэчлэлт	2023	Т	100	100.0
13.1.7	Төрийн албан хаагчийн сургалтын бодлого, чиглэлд шинэчлэл хийх, тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	13.1.7.1	Сургалтын тоо	2023	10	20	20
		13.1.7.2	Гадаад улсын сургалтад хамрагдсан албан хаагч	2023	Т	20	10
		13.1.7.3	Дотоод сургалтад хамрагдсан албан хаагч	2023	40000	80000	66447
		13.1.7.4	Хувийн хэвшлийн оролцоо	2023	Т	2	3
13.1.8	Төрийн албаны судалгааны нэгдмэл, уялдаатай байдлыг хангаж, үр дүнг үйл	13.1.8.1	Судалгааны дүгнэлт, тайлан	2023	Т	3	4

	ажиллагаанд нэвтрүүлнэ.						
13.1.9	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон Нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.	13.1.9.1	Дүрэм, журмын төсөл	2023	Т	1	0
		13.1.9.2	Зөвлөмж, шийдвэр	2023	Т	1	0
13.1.10	Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.	13.1.10.1	Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт	2024	Т	85	78
	Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн аяныг өрнүүлнэ.	13.1.10.2	Сургалт, нөлөөллийн аян	2024	18	20	84
	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ёс зүйн индекс, тогтолцоог нэвтрүүлэх олон улсын туршлагыг судална.	13.1.10.3	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц	2024	Т	25	40
	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бүртгэл, хяналтын цахим системийн хөгжүүлэлтийг хийнэ.	13.1.10.4	Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц	2024	70	90	90

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 10 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан бөгөөд хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн сайн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитор Ж.Мөнхтуул нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/642 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,663.9 сая төгрөгийн 1 хувиар буюу 106.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэвлэл захиалга, сургалт, семинар, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй байх арга хэмжээг авч, төсвийн зарлагыг зүй зохистой, үр ашиг, ач холбогдлыг нь тооцон захиран зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан боловч зарим албан хаагчид улирлын мөнгөн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон байна.

**Илрүүлэлт:** Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны "Урамшуулал олгох тухай", "Мөнгөн урамшуулал олгох тухай" 98, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын 2025 оны "Шагнаж урамшуулах тухай" Б/40 дүгээр тушаалаар зарим албан хаагчид улирлын мөнгөн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, албан хаагчид улирлын мөнгөн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгохгүй байх, баталсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, цахим системд мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

**4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 631.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгснийг аудитын явцад үнэлэхэд 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	9	631.1	9	631.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>631.1</b>	<b>9</b>	<b>631.1</b>	<b>100.0</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт 29.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 77.5 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 52.5 сая төгрөгийн 3 зөрчлийг илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмжийг хүргүүллээ.

### Зөвлөмж

#### 1. Урьдчилгаатай холбоотой

**Илрүүлэлт.** Дараагийн төсвийн жил буюу 2026 оны 01 дүгээр сарын 19-22-ны хооронд Сингапур улсад зохион байгуулах “Дэлхийн засаглалын форум”-д оролцуулах Төрийн албаны зөвлөлийн 5 албан хаагчийн 18.6 сая төгрөгийн, Ёс зүйн хорооны 2 албан хаагчийн 10.4 сая төгрөгийн гадаад томилолтын зардлыг олгож, урьдчилж гарсан зардал дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Санхүү, төсвийг зохистой удирдах, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах”, 43 дугаар зүйлийн 43.5-т “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Баталсан төсвийг тухайн жилдээ зарцуулж, дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг тайлант оны төсвөөс санхүүжүүлэхгүй байх.

#### 2. Худалдан авах ажиллагаатай холбоотой

**Илрүүлэлт.** Тайлант онд худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 1 хуулийн этгээд, 2 хувь хүнтэй төлбөрийг 100.0 хувь урьдчилж төлөх нөхцөлтэй гэрээ байгуулсан байна. Энэ нь тухайн ажил хугацаандаа, эсвэл огт хийгдэхгүй байх тохиолдолд алданги тооцох, төлбөрийг буцаан авч чадахгүй байх эрсдэлтэй байна;
- Төрийн захиргааны албан хаагчдын чадамжийн хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичгийн тусгай шаардлагад урьдчилгаа төлбөр олгохгүйгээр зааж шалгаруулалт явуулсан боловч, тендер шалгаруулалтын дараа шалгарсан компанитай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөр олгохоор гэрээнд тусгаж, 52.5 сая төгрөгийн урьдчилгаа олгосон;
- Тайлант жил хөрөнгө оруулалтын шинж чанартай 17 арга хэмжээг хагас жилээс хойш төлөвлөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 3 удаа нэмэлтээр тусган баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, жилийн эцэст үр дүн гарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна”, 44 дүгээр зүйлийн 44.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ”, Сангийн сайдын 2023 оны

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

A/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.4-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон байхаар төлөвлөгөөнд тусгах, төсөвт тодотгол орсон бол төсөв батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг тайлант жилийн эхэнд бүрэн төлөвлөж, зохион байгуулах, шалгарсан хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулахдаа тендерийн баримт бичигт заасан нөхцөлүүдийг бүрэн тусгаж, гэрээний заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн албаны зөвлөл	1	-	1	-			1	-				
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн албаны зөвлөл	2	18.6	-	-	-	-	2	18.6	-	-	-	-
Ёс зүйн хороо	1	10.4					1	10.4				
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>29.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>29.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн албаны зөвлөл	3	52.5						
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>52.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>52.5</b>

